



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 268

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 нэрийн, нийт 34,154,000.00 (гучин дөрвөн сая нэг зуун тавин дөрвөн мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгө (автомашин)-ийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ч.Амгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэг болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Акталсан хөрөнгийг сэлбэгээр худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Сэлбэгээр худалдсан автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 05 дугаар сарын 13 ны өдрийн  
163 дугаар тогтоолын хавсралт

БУЛГАН АЙМГИЙН ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСЧ СЭЛБЭГЭЭР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

№	Автомашини нэр, төрөл, марк, улсын болон арлын дугаар	Үйлдвэрлэсэн огноо	Ашиглалтанд орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод үнэ /төгрөг/
1	Суудлын автомашин УАЗ-469, Улсын дугаар 65-59 БУА, Арлын дугаар 000100450537948	2006	2006	12,654,000.00	500,000.00
2	Суудлын автомашин Ланд круйзер-80, Улсын дугаар 00-24 БУА, Арлын дугаар FZJ800118142	1995	1995	21,500,000.00	1,000,000.00
НИЙТ ДҮН				34,154,000.00 (гучин дөрвөн сая нэг зуун тавин дөрвөн мянган төгрөг)	1,500,000.00 (нэг сая таван зуун мянган төгрөг)